



“Улаанбаатар хивс” ХК-ийн ТУЗ-ийн
2023 оны 02 сарын 16 өдрийн хурлын
06/2023 дугаар тогтоолын хавсралт

БАТЛАВ. ТУЗ-ИЙН ДАРГА

Ц.ЗОРИГТ

“УЛААНБААТАР ХИВС” ХК-ИЙН ЦАЛИН УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү баримт бичиг нь компани дээр мөрдөгддөг цалин урамшууллын зарчим, хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлно.

Хоёр. ҮНДСЭН ЧИГЛЭЛ

2.1 Цалин урамшууллын талаар компанийн хэмжээнд баримтлах бодлогыг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмуудыг мөрдөнө:

2.1.1 Ижил үнэлэмж бүхий хөдөлмөрт адил цалин, урамшуулал олгох;

2.1.2 Цалин, урамшууллын хуваарилалтанд аливаа хязгаарлал, гадуурхал, тэгш бус байдлыг гаргахгүй байх;

2.1.3 Цалин урамшууллыг ур чадвар болон ажлын үнэлгээ, үр дүнд суурилж тогтоох;

2.1.4 Хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн өсөлтийн зохистой харьцаа болон инфляцийн түвшинтэй уялдуулж, бодит цалингийн өсөлтийг хангах;

2.1.5 Монгол улсын нэгдэн орсон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенц, зохистой хөдөлмөрийн үзэл баримтлалны дагуу ажиллагсдын цалин, урамшууллыг шударга хуваарилах, хөдөлмөрчдийн эвлэлдэн нэгдэх, хамтын хэлэлцээр болон хамтын гэрээ байгуулах эрхийг хүлээн зөвшөөрөх.

2.2 ТУЗ-ийн дэргэдэх цалин, урамшууллын хороо нь компанийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнуудад олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшууллыг олгох санал оруулах, холбогдох хууль, тогтоомж болон ТУЗ-өөс тодорхойлсон бусад асуудлын хүрээнд дараахь хэлбэрээр, зохистой хэмжээг тогтоон олгоно:

2.2.1 Тогтмол цалин,

2.2.2 Хуралд оролцсон цалин,

2.2.3 Компанийн жилийн үр дүнг үндэслэн нэг удаа олгох урамшуулалт цалин,

2.2.4 Мэргэжлийн, өндөр ур чадвартай гүйцэтгэх удирдлагыг тогтвор суурьшилтай ажиллуулах, идэвхжүүлэхэд хангалттай хэмжээний цалин, урамшуулал,



2.2.5 Компанийн үйл ажиллагааны чиглэл болон бусад нөхцөл байдалаас шалтгаалсан бусад хэлбэрийн урамшуулал

2.3 Хороо нь эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримлах бодлогыг ТУЗ-өөр батлуулж, хэрэгжилтэнд нь хяналт тавих, холбогдох хууль, журам, журамд нийцүүлэн санал дүгнэлт гаргана.

2.4 Хороо нь компанийн ажилтнуудын цалин, урамшуулалтай холбоотой дотоод дүрэм, журам, системийн үр дүнг үнэлж, холбогдох хууль тогтоомжинд нийцэж буй байдалд хяналт тавих, компанийн цалингийн бодлого, түвшин, бүтэц, цалин тогтоох журамд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг ТУЗ-д тайлагнаж, ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлнэ.

2.5 Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох нь хувыцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ